


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ  
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,  
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН  
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:**  
2025 оны эхний 4 сарын дүнгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 7,802.0 сая ам.доллар болж 2024 оны мөн үеэс 561.3 сая ам.доллар буюу 6.7 хувиар буурчээ. Экспортын дүн импортын дүнгээс 683.2 сая ам.доллараар

давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа. Гадаад худалдааны бараа эргэлт буурсан нь манай улсын нийт экспорт саарсан, дэлхийн улс орнуудын худалдааны сөргөлдөөнөөс үүдэн дэлхийн эдийн засгийн өсөлт саарч байгаа нь нөлөөлжээ.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

| Үзүүлэлт             | Эхний 4 сар |         |         |         | Өөрчлөлт |       |
|----------------------|-------------|---------|---------|---------|----------|-------|
|                      | 2022        | 2023    | 2024    | 2025    | Дүн      | Хувь  |
| Нийт эргэлтийн бараа | 5,146.9     | 7,745.9 | 8,363.3 | 7,802.0 | -561.3   | -6.7  |
| -Экспорт             | 2,797.0     | 5,085.4 | 4,937.1 | 4,242.6 | -694.5   | -14.1 |
| -Импорт              | 2,349.8     | 2,660.5 | 3,426.2 | 3,559.4 | 133.2    | 3.9   |
| Тэнцэл               | 447.2       | 2,424.9 | 1,510.9 | 683.2   | -827.7   | -54.8 |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **683.2** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 827.7 сая ам.доллараар буурахад экспорт **694.5 сая ам.доллороор буурсан** нь голлон нөлөөлсөн байна.

**Экспорт:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр **4,242.6** сая ам.доллар болж, 2024 оны мөн үетэй харьцуулахад 694.5 сая ам.доллар буюу **14.1 хувиар буурсан** байна. Экспортын орлого буурахад нүүрс, төмрийн хүдэр, алт, газрын тосны

экспорт буурсан нь голлох нөлөөг үзүүлжээ.

**Импорт:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр импорт **3,559.4** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 133.2 сая ам.доллар буюу **3.9 хувиар өссөн** байна.

### Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Монгол Улс дэлхийн 61 оронд бараа экспортлосноос БНХАУ-д 91.2 хувь, Швейцар-т 5.6 хувь, АНУ-д 1.1 хувь, ОХУ-д 0.5 хувь тус тус ногдож нийт экспортын 98.4 хувийг дээрх орнууд эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **3,750.7** сая ам.доллар болж, өмнөх оноос 656.5 сая ам.доллар буюу 14.9 хувиар буурсан бол

эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **491.9** сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 38.0 сая ам.доллар буюу 7.2 хувиар буурсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспортын эдийн засагт эзлэх хувь өндөр байгаа тул экспортын орлогын бууралт нь манай улсын эдийн засгийн өсөлт болон төсвийн орлогод сөрөг нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

| Үзүүлэлт                             | Эхний 4 сар |         |         |         | Өөрчлөлт |       | Нийт экспортод эзлэх хувь |
|--------------------------------------|-------------|---------|---------|---------|----------|-------|---------------------------|
|                                      | 2022        | 2023    | 2024    | 2025    | Дүн      | Хувь  |                           |
| Эрдсийн бүтээгдэхүүний экспорт       | 2,334.6     | 4,507.0 | 4,407.2 | 3,750.7 | -656.5   | -14.9 | 88.4                      |
| Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт | 464.8       | 576.8   | 529.9   | 491.9   | -38.0    | -7.2  | 11.6                      |
| Нийт экспорт                         | 2,799.3     | 5,083.8 | 4,937.1 | 4,242.6 | -694.5   | -14.1 | 100.0                     |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Монгол Улсын экспортын бүтцэд эрдсийн бүтээгдэхүүн давамгайлсан хэвээр байгаа ба эрдсийн салбарын уналт нийт экспортын хэмжээнд хүчтэй нөлөө үзүүлж байна. Эрдсээс бусад салбаруудын экспортын хувь хэмжээ бага, бууралт нь харьцангуй өндөр байгаа нь экспортын төрөлжилт хангалтгүй байгааг харуулж байна.

### ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 44.7 хувийг нүүрс, 34.9 хувийг зэсийн баяжмал, 7.2 хувийг боловсруулаагүй алт, 4.5 хувийг төмрийн

хүдэр, 2.8 хувийг жоншны баяжмал, 2.0 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

**Хүснэгт 3.** Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

| Барааны төрөл                    | Хэмжих нэгж | Эхний 4 сар |       | Өмнөх оны мөн үеэс |             |
|----------------------------------|-------------|-------------|-------|--------------------|-------------|
|                                  |             | 2024        | 2025  | Дүн                | Хувь        |
| Зэсийн баяжмал                   | мян.тн      | 499.4       | 648.7 | 149.3              | 29.9        |
| Нүүрс                            | сая.тн      | 25.0        | 25.0  | -0.1               | -0.2        |
| Төмрийн хүдэр                    | сая.тн      | 2.4         | 2.4   | 0.1                | 3.5         |
| Цайрын баяжмал                   | мян.тн      | 34.8        | 50.1  | 15.3               | 43.8        |
| Алт                              | тн          | 4.2         | 3.0   | -1.3               | -29.8       |
| Түүхий нефть болон газрын тос    | сая.баррель | 1.4         | 1.2   | -0.2               | -17.4       |
| Катодын зэс                      | мян.тн      | 3.8         | 4.2   | 0.4                | 10.5        |
| Жоншны баяжмал                   | мян.тн      | 361.6       | 511.9 | 150.3              | 41.6        |
| Адууны мах                       | мян.тн      | 2.9         | 3.8   | 0.9                | 32.4        |
| Өлөн гэдэс                       | тн          | 164.7       | 387.6 | 222.9              | 135.3       |
| Үхэр, адууны боловсруулсан шир   | сая.дм2     | 11.7        | 0.5   | -11.2              | -95.9       |
| Үхэр, адууны боловсруулаагүй шир | мян.ш       | 181.5       | 22.6  | -158.9             | -87.5       |
| Хонь, хурганы боловсруулсан арьс | сая.дм2     | 0.0001      | 1.4   | 1.3                | 1,124,900.0 |
| Ямаа, ишигний боловсруулсан арьс | сая.дм2     | 17.4        | 4.7   | -12.7              | -73.2       |
| Ямааны самнасан ноолуур          | тн          | 202.7       | 83.7  | -119.0             | -58.7       |
| Ямааны угаасан ноолуур           | тн          | 85.2        | -     | -85.2              | -100.0      |
| Самнаагүй хонины ноос            | мян.тн      | 1.6         | 1.1   | -0.5               | -30.8       |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Хүснэгт 4.** Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

| Барааны төрөл                    | Эхний 4 сар |             | Өмнөх оны мөн үеэс |        | Экспортод эзлэх хувь |
|----------------------------------|-------------|-------------|--------------------|--------|----------------------|
|                                  | 2024        | 2025        | Дүн                | Хувь   |                      |
| Зэсийн баяжмал                   | 871.6       | 1,373.8     | 502.2              | 57.6   | 32.4                 |
| Нүүрс                            | 3,013.8     | 1,836.5     | -1,177.3           | -39.1  | 43.3                 |
| Төмрийн хүдэр                    | 189.6       | 176.1       | -13.5              | -7.1   | 4.2                  |
| Цайрын баяжмал                   | 46.3        | 77.5        | 31.2               | 67.4   | 1.8                  |
| Алт                              | 291.9       | 281.5       | -10.4              | -3.6   | 6.6                  |
| Түүхий нефть болон газрын тос    | 113.3       | 87.7        | -25.6              | -22.6  | 2.1                  |
| Катодын зэс                      | 31.3        | 38.0        | 6.7                | 21.4   | 0.9                  |
| Жоншны баяжмал                   | 76.1        | 108.6       | 32.5               | 42.7   | 2.6                  |
| Адууны мах                       | 10.2        | 13.6        | 3.4                | 33.3   | 0.3                  |
| Өлөн гэдэс                       | 3.0         | 3.7         | 0.7                | 23.3   | 0.1                  |
| Үхэр, адууны боловсруулсан шир   | 0.2         | -           | -0.2               | -100.0 | 0.0                  |
| Үхэр, адууны боловсруулаагүй шир | 0.4         | 0.0         | -0.4               | -95.0  | 0.0                  |
| Хонь, хурганы боловсруулсан арьс | -           | 0.0         | 0.0                | 0.0    | 0.0                  |
| Ямаа, ишигний боловсруулсан арьс | 0.5         | 0.1         | -0.4               | -80.0  | 0.0                  |
| Ямааны самнасан ноолуур          | 10.2        | 13.6        | 3.4                | 33.3   | 0.3                  |
| Ямааны угаасан ноолуур           | 4.1         | -           | -                  | -      | -                    |
| Самнаагүй хонины ноос            | 1.8         | 1.2         | -0.6               | -33.3  | 0.0                  |
| <b>Нийт экспортод эзлэх хувь</b> | <b>94.0</b> | <b>94.6</b> |                    |        | <b>94.6</b>          |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Хүснэгт 5.** Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүний үнэ, төрлөөр

| Барааны төрөл                 | Хэмжих нэгж | Эхний 4 сар |          | Өмнөх оны мөн үеэс |       |
|-------------------------------|-------------|-------------|----------|--------------------|-------|
|                               |             | 2024        | 2025     | Дүн                | Хувь  |
| Чулуун нүүрс                  | тн/ам.дол   | 122.3       | 77.2     | -45.1              | -36.9 |
| Зэсийн баяжмал                | тн/ам.дол   | 1,745.4     | 2,117.8  | 372.4              | 21.3  |
| Төмрийн хүдэр, баяжмал        | тн/ам.дол   | 80.1        | 71.9     | -8.2               | -10.2 |
| Цайрын баяжмал                | тн/ам.дол   | 1,330.0     | 1,547.1  | 217.1              | 16.3  |
| Хайлуур жоншны хүдэр, баяжмал | тн/ам.дол   | 210.6       | 212.2    | 1.6                | 0.8   |
| Молибдены баяжмал             | тн/ам.дол   | 14,922.7    | 16,065.4 | 1,142.7            | 7.7   |
| Алт                           | кг/ ам.дол  | 69,367.6    | 95,258.2 | 25,890.6           | 37.3  |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспортод голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**Нүүрс:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 1,836.5 сая ам.долларын 25.0 сая.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 1,177.3 сая ам.доллар буюу 39.1 хувиар, биет хэмжээ 0.1 сая.тн буюу 0.2 хувиар тус тус буурсан байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ 77.2 ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 45.1 ам.доллар буюу 36.9 хувиар буурлаа. Нүүрсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Зэсийн баяжмал:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 1,373.8 сая ам.долларын 648.7 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 502.2 сая ам.доллар буюу 57.6 хувиар, биет хэмжээгээр 149.3 мян.тн буюу 29.9 хувиар тус тус өссөн байна. Нэг тонн зэсийн баяжмалын экспортын дундаж 2,117.8 үнэ ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 372.4 ам.доллар буюу 21.3 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Алт:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 281.5 сая ам.долларын 3.0 тн алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 10.5 сая ам.доллар буюу 3.6 хувиар, биет хэмжээ 1.3 тн буюу 29.8 хувиар тус тус буурсан байна. Нэг кг алтны экспортын дундаж үнэ 95,258.2 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 25,890.6 ам.доллар буюу 37.3 хувиар өссөн байна. Алтны 84.2 хувийг Швейцар, 14.7 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна.

**Төмрийн хүдэр, баяжмал:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 176.1 сая ам.долларын 2.4 сая.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 13.5 сая ам.доллар буюу 7.1 хувиар буурч, биет хэмжээ 0.1 сая.тн буюу 3.5 хувиар өссөн байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна. Нэг тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 71.9 ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 8.2 ам.доллар буюу 10.2 хувиар буурсан байна.

**Цайрын баяжмал:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 77.5 сая ам.долларын 50.1 мян.тн цайрын баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 31.2 сая ам.доллар буюу 67.3 хувиар, биет хэмжээ 15.3 мян.тн буюу 43.8 хувиар тус тус өссөн байна. Нэг тонн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 1,547.1 ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 217.1 ам.доллар буюу 16.3 хувиар өссөн байна. Цайрын баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**Жоншны хүдэр, баяжмал:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 108.6 сая ам.долларын 511.9 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 32.5 сая ам.доллар буюу 42.7 хувиар, биет хэмжээ 150.3 мян.тн буюу 41.6 хувиар тус тус өссөн байна. Жоншны хүдэр, баяжмалын 88.1 хувийг БНХАУ, 11.8 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

**Түүхий нефть болон газрын тос:** 2025 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр 87.7 сая ам.долларын 1.2 сая.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүн 25.5 сая ам.доллар буюу 22.5 хувиар, биет хэмжээ 0.2 сая.бар буюу 17.4 хувиар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

- Эрдэс баялгийн экспортын орлого, зах зээл (ялангуяа БНХАУ)-ын нөхцөл байдлаас хамаарч савлаж байна.
- Зэс, жонш, цайрын экспорт нэмэгдэж буй нь эерэг үзүүлэлт юм.
- Нүүрс, газрын тос, алтны экспортын бууралт нийт экспортод болон Монгол Улсын төсвийн орлогод сөргөөр нөлөөлж байна.
- Монгол Улсын экспортын бүтэц хязгаарлагдмал, эрсдэлтэй хэвээр байна.

## Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Манай Улс дэлхийн 130 орноос гарал үүсэлтэй бараа импортлосноос БНХАУ-д 35.3 хувь; ОХУ-д 25.7 хувь; Япон-д 13.2 хувь; АНУ-д 4.4 хувь; БНСУ-д 4.1 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн 85.4 хувийг эзэлж байна.

Нийт импортын **22.5** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **77.5** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **800.9** сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 33.0 сая ам.доллараар буюу 4.0 хувиар буурсан байна.

Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **2,758.5** сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 166.2 сая ам.доллар буюу 6.4 хувиар өссөн байна.

**Хүснэгт 6.** Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

| Үзүүлэлт                            | Эхний 4 сар |         |         |         | Өөрчлөлт |      | Нийт импортод эзлэх хувь |
|-------------------------------------|-------------|---------|---------|---------|----------|------|--------------------------|
|                                     | 2022        | 2023    | 2024    | 2025    | Дүн      | Хувь |                          |
| Эрдсийн бүтээгдэхүүний импорт       | 505.3       | 644.6   | 833.9   | 800.9   | -33.0    | -4.0 | 22.5                     |
| Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт | 1,844.0     | 2,015.7 | 2,592.3 | 2,758.5 | 166.2    | 6.4  | 77.5                     |
| Нийт импорт                         | 2,349.3     | 2,660.4 | 3,426.2 | 3,559.4 | 133.2    | 3.9  | 100.0                    |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 23.1 хувь, эрдэс бүтээгдэхүүн 22.5 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 20.2 хувь, үндсэн

төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 7.7 хувь, хүнсний бэлэн бүтээгдэхүүн 7.5 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 5.2 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр**

/сая ам.доллар/

| №  | Барааны нэр                                                                                               | Эхний 4 сар    |                | Өөрчлөлт     |             | Нийт импортод эзлэх хувь |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------|----------------|----------------|--------------|-------------|--------------------------|
|    |                                                                                                           | 2024           | 2025           | Дүн          | Хувь        |                          |
| 1  | Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн                                                       | 38.2           | 41.9           | 3.6          | 9.5         | 1.2                      |
| 2  | Ургамлын гаралтай бүтээгдэхүүн                                                                            | 63.0           | 53.8           | -9.2         | -14.6       | 1.5                      |
| 3  | Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх                                                               | 13.1           | 17.0           | 3.9          | 29.8        | 0.5                      |
| 4  | Хүнсний бэлэн бүтээгдэхүүн                                                                                | 241.7          | 268.3          | 26.6         | 11.0        | 7.5                      |
| 5  | <b>Эрдэс бүтээгдэхүүн</b>                                                                                 | <b>833.9</b>   | <b>800.9</b>   | <b>-33.0</b> | <b>-4.0</b> | <b>22.5</b>              |
| 6  | Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн                                                    | 176.2          | 186.0          | 9.8          | 5.5         | 5.2                      |
| 7  | Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс                                    | 110.6          | 107.2          | -3.4         | -3.1        | 3.0                      |
| 8  | Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл                     | 2.9            | 2.8            | -0.1         | -4.3        | 0.1                      |
| 9  | Мод, модон эдлэл                                                                                          | 27.0           | 35.2           | 8.2          | 30.3        | 1.0                      |
| 10 | Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс                                                                | 25.4           | 22.8           | -2.6         | -10.2       | 0.6                      |
| 11 | Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл                                                                     | 36.5           | 35.8           | -0.8         | -2.1        | 1.0                      |
| 12 | Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл                                                                    | 11.2           | 13.1           | 1.9          | 17.2        | 0.4                      |
| 13 | Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн       | 63.9           | 66.8           | 2.8          | 4.5         | 1.9                      |
| 14 | Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос                                           | 1.5            | 1.3            | -0.2         | -12.1       | 0.0                      |
| 15 | Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн                                                         | 262.5          | 275.3          | 12.8         | 4.9         | 7.7                      |
| 16 | <b>Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг</b>                   | <b>690.5</b>   | <b>718.4</b>   | <b>27.9</b>  | <b>4.0</b>  | <b>20.2</b>              |
| 17 | <b>Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги</b>                                 | <b>747.5</b>   | <b>821.4</b>   | <b>73.9</b>  | <b>9.9</b>  | <b>23.1</b>              |
| 18 | Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги | 40.4           | 47.5           | 7.2          | 17.8        | 1.3                      |
| 19 | Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа                                                                          | 39.7           | 42.4           | 2.7          | 6.7         | 1.2                      |
| 20 | Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс                         | 0.0            | 0.0            | 0.0          | 148.7       | 0.0                      |
| 21 | Бусад                                                                                                     | 0.5            | 1.6            | 1.1          | 197.9       | 0.0                      |
|    | <b>ДҮН</b>                                                                                                | <b>3,426.2</b> | <b>3,559.4</b> | <b>133.2</b> | <b>3.9</b>  | <b>100.0</b>             |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Импорт голлон нөлөөлсөн бараа, бүтээгдэхүүн**

Суудлын автомашин импорт:

Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 44,770 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 688 ширхэг буюу 1.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 519 ширхгээр буурсан, бусад суудлын автомашин 1,207 ширхгээр тус тус өссөн.

**Хүснэгт 8.** Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

| Барааны төрөл | Тоо хэмжээ |         | Өөрчлөлт |      | Татварын дүн |         | Өөрчлөлт |      |
|---------------|------------|---------|----------|------|--------------|---------|----------|------|
|               | 2024.04    | 2025.04 | Дүн      | Хувь | 2024.04      | 2025.04 | Дүн      | Хувь |
| Хос тэжээлт   | 37,332     | 36,813  | -519     | -1.4 | 285.8        | 313.7   | 27.9     | 9.8  |
| Бусад         | 6,750      | 7,957   | 1,207    | 17.9 | 97.6         | 142.0   | 44.5     | 45.6 |
| Нийт          | 44,082     | 44,770  | 688      | 1.6  | 383.4        | 455.7   | 72.4     | 18.9 |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автобензин, дизелийн түлшний импорт:

Монгол Улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2025 оны эхний 4 сард **860.5** мян.тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

**Хүснэгт 9.** Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

| Төрөл       | Барааны төрөл           | Тоо хэмжээ /мян.тн/ |         | Өөрчлөлт |       | Ногдуулсан татварын дүн |         | Өөрчлөлт |       |
|-------------|-------------------------|---------------------|---------|----------|-------|-------------------------|---------|----------|-------|
|             |                         | 2024.04             | 2025.04 | Дүн      | Хувь  | 2024.04                 | 2025.04 | Дүн      | Хувь  |
| Автобензин  | A-80                    | 2.4                 | 0.3     | -2.1     | -87.5 | 1.0                     | 0.1     | -0.9     | -90.0 |
|             | A-92                    | 283.8               | 263.5   | -20.3    | -7.2  | 77.0                    | 72.4    | -4.6     | -6.0  |
|             | A-95 болон түүнээс дээш | 7.0                 | 5.3     | -1.7     | -24.3 | 5.0                     | 3.6     | -1.4     | -28.0 |
| Дизель түлш |                         | 530.6               | 591.4   | 60.8     | 11.5  | 219.1                   | 229.7   | 10.6     | 4.8   |
| Нийт        |                         | 823.8               | 860.5   | 36.7     | 4.5   | 302.1                   | 305.8   | 3.7      | 1.2   |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гаалийн байгууллага нь 2025 оны эхний 4 сард нийт **2,271.3** тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **2,115.5** тэрбум төгрөгийг төвлөрүүлж, гүйцэтгэл **93.1** хувьтай байна. Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 143.5 тэрбум төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн байна.

**Хүснэгт 10.** Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

| Үзүүлэлт                                       | 2024.04        | 2025.04        |                | Өмнөх оны мөн үетэй харьцуулахад |             | Орлогын биелэлтийн хувь |
|------------------------------------------------|----------------|----------------|----------------|----------------------------------|-------------|-------------------------|
|                                                | Гүйц.          | Төл.           | Гүйц.          | Зөрүү                            | Хувь        | Хувь                    |
| <b>Нийт орлого</b>                             | <b>1,972.0</b> | <b>2,271.3</b> | <b>2,115.5</b> | <b>143.5</b>                     | <b>7.3</b>  | <b>93.1</b>             |
| Татварын дүн                                   | 1,925.6        | 2,226.9        | 2,066.3        | 140.7                            | 7.3         | 92.8                    |
| Гаалийн албан татвар                           | 511.6          | 625.8          | 556.4          | 44.8                             | 8.8         | 88.9                    |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар                 | 1,146.9        | 1348.8         | 1215.3         | 68.4                             | 6.0         | 90.1                    |
| Архи, дарсны онцгой албан татвар               | 16.3           | 19.1           | 18.8           | 2.5                              | 15.3        | 98.4                    |
| Тамхины онцгой албан татвар                    | 40.1           | 34.6           | 43.1           | 3.0                              | 7.5         | 124.6                   |
| Шар айргийн онцгой албан татвар                | 2.5            | 3.2            | 5.7            | 3.2                              | 128.0       | 178.1                   |
| Суудлын автомашины онцгой албан татвар         | 198.4          | 176.3          | 217.8          | 19.4                             | 9.8         | 123.5                   |
| Автобензин, дизель түлшний онцгой албан татвар | 1.3            | 5.7            | 1.1            | -0.2                             | -15.4       | 19.3                    |
| Автобензин, дизель түлшний албан татвар        | 8.5            | 13.4           | 8.1            | -0.4                             | -4.7        | 60.4                    |
| Экспортын татвар                               | 0.013          | 0.013          | -              | 0.0                              | -100.0      | 0.0                     |
| <b>Хураамж</b>                                 | <b>43.1</b>    | <b>38.7</b>    | <b>44</b>      | <b>0.9</b>                       | <b>2.1</b>  | <b>113.7</b>            |
| <b>Өөрийн орлого</b>                           | <b>3.3</b>     | <b>5.7</b>     | <b>5.2</b>     | <b>1.9</b>                       | <b>57.6</b> | <b>91.2</b>             |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 143.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 68.4 тэрбум;
- Гаалийн албан татвар 44.8 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 19.4 тэрбум төгрөг;
- Шар айргийн онцгой албан татвар 3.2 тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар 3.0 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 2.5 тэрбум төгрөг;
- Өөрийн орлого 1.9 тэрбум төгрөг;
- Хураамжийн орлого 0.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

## Тав. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татвараас чөлөөлөгдсөн импорт нь 2025 оны эхний 4 сард 597.2 тэрбум төгрөгт хүрч, түүнд ногдуулсан 89.6 тэрбум төгрөгийн татварыг хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Үүнд:

**1.**Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан тусламжийн хүрээнд 51.7 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 7.9 тэрбум тэрбум төгрөг;

**2.**БНМАУ-ЗСБНХУ-ын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээр, мөн УИХ-ын 2016-09-07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөгдөх тухай хууль”-аар Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг нь 131.2 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 20.4 тэрбум төгрөг;

**3.**Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг болох 5.7 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 0.8 тэрбум төгрөг;

**4.**Засгийн газрын болон Олон улсын байгууллагатай байгуулсан зээлийн хүрээнд 63.5 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 9.6 тэрбум төгрөг;

**5.**Хөдөө, аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис бүхий нийт 0.03 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 0.003 тэрбум төгрөг;

**6.**Бусад татварын хуулийн зүйл заалтуудаар 94.1 тэрбум төгрөгийн дүн бүхий бараанд ногдуулсан 11.9 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлсөн байна. Үүнээс:

Гаалийн тариф, татварын тухай хуулийн 38.1.21. “Засгийн газраас энэ хуулийн 40.5-д заасны дагуу тогтоосон төслийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмж”-ийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн заалтыг үндэслэн

- Дулааны цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлэх “Райд Монголиа” ХХК болон Бөөрөлжүүтийн 300мВт-ын цахилгаан станц “Цэцэнс Майнинг энд Энержи” ХХК 223.1 тэрбум төгрөгийн бараанд ногдуулсан 34.6 тэрбум төгрөгийн татварыг тус тус чөлөөлжээ.

Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **10.0** тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

| Үзүүлэлт                                                                                                            | 2024.04      |                  | 2025.04      |                  | Өөрчлөлт     |                  |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|------------------|--------------|------------------|--------------|------------------|
|                                                                                                                     | Импортын дүн | Чөлөөлсөн татвар | Импортын дүн | Чөлөөлсөн татвар | Импортын дүн | Чөлөөлсөн татвар |
| Хөдөө, аж ахуйн зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис                                              | 60.4         | 6.3              | 0.03         | 0.003            | -60.4        | -6.3             |
| Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж                                                                | 123.9        | 19.5             | 51.7         | 7.9              | -72.2        | -11.5            |
| Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ болон газрын тосны компаниудын тоног төхөөрөмж                                      | 146.5        | 22.7             | 131.2        | 20.4             | -15.3        | -2.3             |
| Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг | 3.5          | 0.5              | 5.7          | 0.8              | 2.3          | 0.4              |
| Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг                                                         | 27.7         | 4.7              | 223.1        | 34.6             | 195.4        | 30.0             |
| Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл                                                                   | 87.0         | 13.2             | 63.5         | 9.6              | -23.4        | -3.6             |
| Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж                                                                                | 30.6         | 4.7              | 27.8         | 4.3              | -2.8         | -0.4             |
| Бусад                                                                                                               | 185.7        | 28.1             | 94.1         | 11.9             | -91.6        | -16.2            |
| <b>Нийт</b>                                                                                                         | <b>665.3</b> | <b>99.7</b>      | <b>597.2</b> | <b>89.6</b>      | <b>-68.1</b> | <b>-10.0</b>     |

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС